

# ОЮУТНЫ АКАДЕМИК ГҮЙЦЭТГЭЛ, СУРАЛЦАХ СЭДЛИЙГ ХҮЙСЭЭР ХАРЬЦУУЛАН СУДАЛСАН НЬ (ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ОЮУТНУУДЫН ЖИШЭЭН ДЭЭР)

*С. Ариунцэцэг*  
*Магистр*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль*  
*Нийгэм, хүмүүнлэгийн сургууль*

*Б. Үүрийнтуяа*  
*Магистр*

*ШУА-ийн Тархи, сэтгэл судлалын хүрээлэн*

*Б. Найдан*

*Монгол улсын их сургууль*

*naidan\_b@mas.ac.mn*

*Хураангуй:* This study aimed to compare university students' academic performance and learning motivation by gender. A total of 400 undergraduate students from the Mongolian University of Science and Technology (MUST) participated. Methodologically, learning motivation was assessed using the internationally recognized Academic Motivation Scale (AMS), while academic performance was measured by the students' cumulative Grade Point Average (GPA). The results indicated that students' learning motivation had a significant influence on their academic performance. Additionally, scholastic performance and learning motivation differed by gender. Notably, extrinsic motivation was high among all participants, and male students reported lower levels of both learning motivation and academic performance compared to female students. These results are in line with earlier studies, demonstrating that one of the main elements affecting academic achievement is learning motivation. Therefore, enhancing students' motivation could potentially lead to improved academic outcomes.

*Түлхүүр үг:* Intrinsic motivation, extrinsic motivation, student, career choice

## **УДИРТГАЛ**

Дээд боловсролын байгууллагууд нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах сайн боловсон хүчнийг бэлтгэх үндсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй бөгөөд үүний чанар үр өгөөжийг үнэлэх урьдал алхам нь оюутны академик гүйцэтгэл юм (York et al., 2015). Академик гүйцэтгэл нь оюутны амжилт чанарыг

илэрхийлэх нэг нэгж бөгөөд дан ганц боловсролын байгууллагаас бус нийгэм эдийн засгийн байдал, хувь хүний сэтгэл зүйн сайн сайхан байдалтай шууд холбогдог (Owens et al., 2012; Turashvili & Japaridze 2012). Сэтгэл зүйн сайн сайхан байдал алдагдах тэр дундаа сэтгэлийн түгшүүр, сэтгэл гутралын шинж тэмдэг үүсэх нь оюутны академик гүйцэтгэлд шууд

болон дам байдлаар нөлөөлдөг ба цаашлаад шинж тэмдэг хүндрэх үед сургууль завсардах, танин мэдэхүйн үйл ажиллагаа алдагдах зэрэгт асуудлууд үүсдэг (Eisenberg et al., 2009). Өмнөх судалгаагаар Америкийн нэгдсэн улсын хувьд сэтгэл гутралын шинж тэмдэг удаан хугацаанд мэдэрч буй оюутнууд бусад хэвийн оюутнуудтай харьцуулахад хичээлийн хувьд 2.5 дахин бага үнэлгээ авах (*GPA*), сургуулиа орхих, завсардах байдал 1.7 дахин их байсан (Frijnd et al., 2007). Мөн сэтгэл гутрал болон сэтгэл түгшлийн шинжүүд нь ажлын **ой санамж алдагдах, анхаарал төвлөрөл буурах, өөртөө итгэх итгэлийг бууруулах**, улмаар суралцах чадварыг сулруулдаг байна. (Beiter et al., 2014). Харин европын улсуудад хийгдсэн судалгаагаар айдас, түгшүүрийн шинж тэмдэг ихтэй оюутнууд шалгалтдаа тааруу үнэлгээ авах магадлал 1.8 дахин их байсан ба энэ нь академик гүйцэтгэлийн 15 хүртэлх хувийг эзэлж байв (Stallman, 2010). Академик гүйцэтгэлд нөлөө үзүүлдэг өөр гол хүчин зүйл бол суралцах сэдэл бөгөөд оюутны өөрийн хүсэл эрмэлзэлтэй холбогддог (Ryan & Deci, 2000). Дотоод сэдэл өндөртэй оюутнууд гадаад сэдэл давамгайл оюутнуудтай харьцуулахад илүү сурах хүсэл эрмэлзэл өндөр байхын дээр академик гүйцэтгэл сайн байдаг (Vallerand et al., 1992). Дотоод сэдэлтэй оюутнууд хичээлд илүү идэвхтэй оролцдог, илүү гүнзгий ойлголттой болдог бол гадаад сэдэл нь түр зуурын урамшуулалд төвлөрдөг гэж үздэг (Deci & Ryan, 2000).


Суралцах сэдэл болон гүйцэтгэлд **хүйсийн ялгаа** тод ажиглагддаг. Өмнөх судалгаагаар эмэгтэй оюутнууд эрэгтэйчүүдээс илүү **сурлагын гүйцэтгэл, хариуцлагатай хандлага, сэдэлтэй** байдлаар ялгарч байсан (Voyeg & Voyeg, 2014). Мөн оюутны амжилт, суралцах сэдэл нь жендерийн хэвшмэл ойлголттой холбоотой байсныг онцлох нь зүйтэй юм (Eccles & Wang, 2012).

Иймд энэхүү судалгаагаар их сургуулийн оюутнуудын академик гүйцэтгэл болон түүнд нөлөө үзүүлж буй суралцах сэдлийг хүйсийн хувьд харьцуулан судлахыг зорьсон болно.

#### **МАТЕРИАЛ АРГА ЗҮЙ:**

Монгол улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуульд суралцаж буй оюутнуудаас энэхүү судалгааг авсан бөгөөд түүврийн суурь хэмжээг энгийн санамсаргүй түүврийн арга ( $n=384$ ;  $CI=0.95$ ,  $E=0.05$ ,  $\rho=0.5$ ) ашиглан тооцсон. Судалгаанд 1) бүтэн цагийн нойр авсан (*6-аас дээш цаг унтаж амарсан*), 2) бакалаврын түвшинд идэвхтэй төлөвт суралцаж буй оюутан, 3) 25-аас доош настай, 4) асуумж хэрэглэгдэхүүнийг бүрэн бөглөсөн байх гэсэн нийт 4 үзүүлэлтийг шалгуур болгон авсан.

Зураг 1. Түүвэрлэлт ба судалгаанд оролцогчид



Энэхүү судалгаанд сайн дурын үндсэн дээр нийт 417 оюутан хамрагдсанаас ахисан түвшинд суралцаж буй 4, насны шалгуур хангаагүй 13 хүний үр дүнг хүчингүйд тооцон нийт 400 оюутны өгөгдөл дээр дүн шинжилгээ хийсэн болно.

Судалгааг 2025оны 02-р сараас 3-р сарын хооронд, танхимаар явуулсан бөгөөд оролцогч бүрд судалгааны зорилго, заавар чиглэлийг танилцуулан зөвшөөрөл авсан.

Академик гүйцэтгэл

Оюутны академик гүйцэтгэлийг нийт суралцах хугацаан дахь голч дүн (GPA)-р хэмжсэн бөгөөд тухайн хариултын үнэн зөвийг бататгах зорилгоор нэмэлтээр хувьчилсан оноо (0-100 хүртэлх)-г тодруулсан. Судалгаанд оролцогчийн хоёр хариултыг ангилсан өгөгдлийн шинжилгээгээр шинжилж үзэхэд ач холбогдолтой ( $p=.000$ ) байв. Энэ нь судалгаанд тодруулсан академик гүйцэтгэлийг хэмжих голч дүн нь үнэн зөв болохыг илтгэж байна.

Оюутны суралцах сэдэл

Оюутны суралцах сэдлийг 1992 онд анхлан боловсруулагдсан олон улсад өргөн ашигладаг Academic Motivation Scale (AMS-C 28) хэрэглэгдэхүүнийг

ашиглан үнэлсэн. Уг асуумж нь нийт 28 асуултаас бүрдэх оюутны дотоод болон гадаад сэдлийг нийт 7 дэд хэмжүүрээр тодорхойлдог бөгөөд 1-7 хүртэлх оноогоор (1= огт санал нийлэхгүй, 7= бүрэн санал нийлнэ) үнэлэгддэг (Vallerand et al., 1992). Хэрэглэгдэхүүнийг зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэйгөөр авч орчуулан ашиглаж буй бөгөөд асуулгын найдварт ( $\alpha=.899$ ,  $\omega=.914$ ) болон бол тохироц чанар ( $KMO=.915$ ,  $p<.001$ ,  $CFI=.879$ ,  $TLI=.859$ ,  $RMSEA=.074$ ) сайн байсан. Энэ нь тухайн хэрэглэгдэхүүн оюутны сэдлийг бүрэн үнэлж чадахыг илтгэж байна.

Статистик шинжилгээ

Өгөгдлийн тархалтыг колмогоров смирновын тестээр шинжилж үзэхэд хэвийн бус ( $p=.000$ ) байсан. Иймд ангилсан өгөгдлийн хамаарлыг эксакт (exact) тест, тасралтгүй хувьсагч хоорондын хамаарлыг спирманы тестээр шинжилсэн. Бүлэг хоорондын харьцуулалтыг Манн Уитни Ю (mann-whitney U) тест ашиглан үнэлэв. Тархалт хэвийн бус байсан ч төв хязгаарын теоремд үндэслэн хамаарлын шинжилгээний үр дүнгийн дараа Стэпвайс (stepwise) аргыг ашиглан олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээ хийсэн.

## ҮР ДҮН

Энэхүү судалгаанд Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцаж буй 417 оюутан сайн дурын үндсэн дээр хамрагдсанаас шалгуур үзүүлэлтийг хангасан 400 (нэрэгтэй=230,

пэмэгтэй=170) оролцогчийн өгөгдөл дээр дүн шинжилгээ хийв.

*Хүснэгт 6. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл*

Ерөнхий мэдээлэл	Нийт түүвэр	Оюутан хүйсээр	
		Эрэгтэй	Эмэгтэй
<b>Нас</b>	19.5 (±1.5)	19.3 (±1.5)	19.8 (±1.6)
<b>Суралцаж буй түвшин</b>			
1-р курс	58.5	66.1	48.2
2-р курс	15.5	13.0	18.8
3-р курс	10.5	7.0	15.3
4-р курс	11.5	12.2	10.6
5-р курс	3.0	0.9	5.9
6-р курс	1.0	0.9	1.2
<b>Гэрлэлтийн байдал</b>			
Ганц бие	76.5	75.2	78.2
Батлуулсан гэр бүлтэй	0.5	0.4	0.6
Батлуулаагүй гэр бүлтэй	1.8	1.7	1.8
Үерхэж байгаа	21.3	22.6	19.4
<b>Өрхийн орлого</b>			
500.000-аас доош	5.3	7.4	2.4
500.000-1.000.000	8.3	7.8	8.8
1.000.000-1.500.000	15.3	13.5	17.6
1.500.000-2.000.000	17.3	15.2	20.0
2.000.000-2.500.000	14.5	14.8	14.1
2.500.000-аас дээш	39.5	41.3	37.1
<b>Мэргэжил сонголт</b>			
Өөрийн хүсэлтээр	80.0	82.2	77.1
Өөрийн хүсэлтээр бус	20.0	17.8	22.9
<b>Сургууль сонголт</b>			
Өөрийн хүсэлтээр	82.3	85.2	78.2
Өөрийн хүсэлтээр бус	17.8	14.8	21.8
<b>Нийт</b>	<b>n=400</b>	<b>n=230</b>	<b>n=170</b>

Нийт судалгаанд оролцогчдын 58.5 хувийг нэгдүгээр түвшний суралцагч байсан. Мөн судлуулагчдын 2.3 хувь нь гэр бүлтэй, 21.3 хувь нь хосын харилцаатай байв. Мэргэжил сонголтын хувьд нийт оролцогчдын 80

хувь, сургууль сонголтын 82.3 хувь нь өөрийн хүсэлтээр сонгосон байна. (Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллийн дэлгэрэнгүйг хүснэгт 1-ээс харна уу).

Хүснэгт 7. Суралцах сэдлийн үр дүн

Суралцах сэдэл	Дундаж ±SD
<b>Дотоод сэдэл</b>	13.3±3.36
Мэдлэг олж авах сонирхол	4.9±1.17
Хувийн амжилт гаргах сонирхол	4.3±1.25
Сэтгэл ханамж, сэтгэл хөдлөлийн таашаал	4.1±1.35
<b>Гадаад сэдэл</b>	15.1±3.07
Хувийн үнэт зүйлд нийцүүлэх	5.2±1.16
Бусдын үнэлгээнд нийцүүлэх	4.5±1.41
Гадаад урамшуулал, дарамтаас хамаарах	5.5±1.16
<b>Суралцах сонирхолгүй байх</b>	3.3±1.56

Тайлбар: SD-Стандарт хазайлт

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн суралцах сэдлийн үр дүнг тооцоолоход нийт оролцогчдын хувьд дотоод сэдлээс илүү гадаад сэдэл өндөр үзүүлэлттэй байв. Үүний дараа суралцах сэдэл болон академик гүйцэтгэл хоорондын хамаарлыг шинжилж үзэхэд мэдлэг олж авах сонирхол ( $r=.148$ ,  $p=.003$ ), хувийн амжилт олж авах сонирхол ( $r=.174$ ,  $p=.001$ ) гэсэн дотоод сэдлийн дэд хэмжүүрүүд болон хувийн үнэт зүйлд нийцүүлэх хандлага ( $r=.145$ ,  $p=.004$ ), бусдын үнэлгээнд нийцүүлэх хандлага ( $r=.136$ ,  $p=.007$ ), гадаад урамшуулал болон дарамт ( $r=.122$ ,  $p=.015$ ) гэсэн гадаад сэдлийн дэд үзүүлэлтүүд нь академик гүйцэтгэлтэй сул хамааралтай байв. Энэ нь гадаад болон дотоод сэдэл аль нь давамгайл

байгаагаас үл шалтгаалан сэдэл нэмэгдэх үед оюутны академик гүйцэтгэлийн үзүүлэлт даган нэмэгдэж буйг илтгэнэ. Харин академик гүйцэтгэл нь суралцах сонирхолгүй байх үзүүлэлттэй ( $r=-.247$ ,  $p<.001$ ) урвуу хамааралтай байсан нь оюутны суралцах сонирхол багасах тусам академик гүйцэтгэл мөн багасаж байгааг илтгэж байна. Хамаарлын шинжилгээний үр дүнг бататгах болон тухайн сэдэл нь академик гүйцэтгэлийг хэдэн хувьтай тайлбарлаж байгааг шалгах зорилгоор олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээ хийж үзэхэд хувийн амжилт гаргах сонирхол болон суралцах сонирхолгүй байх гэсэн хоёр дэд хэмжүүр дээр ач холбогдолтой байсан.

Хүснэгт 8. Регрессийн шинжилгээний үр дүн

Хувьсагч	B	95% CI	SE	$\beta$	t	p
Хувийн амжилт гаргах сонирхол	.099	[.046, .152]	.027	-.177	3.66	.001
Суралцах сонирхолгүй байх	-.085	[-.128, -.043]	.022	-.191	-3.94	.001

Тайлбар: B- стандарт бус утга, CI-итгэлийн интервал, SE- стандарт алдаа,  $\beta$ -стандарт утга, p-ач холбогдлын утга

Регрессийн шинжилгээний үр дүнд хувийн амжилт гаргах сонирхол болон суралцах сонирхолгүй байх хоёр

үзүүлэлт академик гүйцэтгэлийн 7.2 хувийг тайлбарлаж (тогтмол утга: 3.159,  $F(13.99)=15.42$ ,  $p<.001$ ,

$R^2=.072$ ) байв. Энэ нь хамаарлын шинжилгээний үр дүнг бататгасан ба сэдэл нэмэгдэх үед академик гүйцэтгэл сайжирч ( $B = 0.099$ ,  $SE = 0.027$ ,  $\beta = 0.177$ ,  $t = 3.66$ ,  $p < .001$ ) харин

суралцах сонирхол багасах үед гүйцэтгэл суларч ( $B = -0.085$ ,  $SE = 0.022$ ,  $\beta = -0.191$ ,  $t = -3.94$ ,  $p < .001$ ) байгааг илтгэж байна.

*Хүснэгт 9. Суралцах сэдэл болон академик гүйцэтгэлийг хүйсээр харьцуулсан байдал*

Хувьсагч	$p$	Mean Rank
<b>Дотоод сэдэл</b>	.360	Эмэгтэй (206.65)>Эрэгтэй (195.95)
Мэдлэг олж авах сонирхол	.173	Эмэгтэй (209.63)>Эрэгтэй (193.75)
Хувийн амжилт гаргах сонирхол	.660	Эмэгтэй (203.45)>Эрэгтэй (198.32)
Сэтгэл ханамж, сэтгэл хөдлөлийн таашаал	.536	Эмэгтэй (204.66)>Эрэгтэй (197.43)
<b>Гадаад сэдэл</b>	.062	Эмэгтэй (213.05)>Эрэгтэй (191.22)
Хувийн үнэт зүйлд нийцүүлэх	.169	Эмэгтэй (209.73)>Эрэгтэй (193.68)
Бусдын үнэлгээнд нийцүүлэх	.084	Эмэгтэй (212.11)>Эрэгтэй (191.92)
Гадаад урамшуулал, дарамтаас хамаарах	<b>.034</b>	Эмэгтэй (214.71)>Эрэгтэй (190.00)
<b>Суралцах сонирхолгүй байх</b>	<b>.041</b>	Эрэгтэй (186.80)<Эмэгтэй (210.63)
<b>Академик гүйцэтгэл</b>	<b>.001</b>	Эмэгтэй (236.91)>Эрэгтэй (173.58)

*Тайлбар: Mean Rank-дундаж ранк, p- ач холбогдлын утга*

Суралцах сэдэл болон академик гүйцэтгэлийг хүйсийн хувьд харьцуулан авч үзэхэд суралцах сэдлийн гадаад урамшуулал, дарамт ( $U=17134.5$ ,  $p=.034$ ), суралцах сонирхолгүй байх ( $U=17220.5$ ,  $p=.041$ ) гэсэн дэд хэмжүүрүүд болон академик гүйцэтгэл ( $U=13359.5$ ,  $p<.001$ ) ялгаатай байв. Тодруулбал эрэгтэй оюутнуудтай харьцуулахад эмэгтэй оюутнууд суралцах сэдэл өндөртэй байгаа ба академик гүйцэтгэл ч мөн өндөр байна. Харин эрэгтэй оюутнуудын хувьд суралцах сонирхол бага байгаагаас гадна академик гүйцэтгэл ч мөн ижил байна. Суралцах сэдэл болон академик гүйцэтгэл нь оюутны мэргэжил сонголт болон сургууль сонголтөөс хамаарч ялгаатай эсэхийг судлахад мэргэжил сонголт нь мэдлэг олж авах

хандлага ( $U=9482$ ,  $p<.001$ ), хувийн үнэт зүйлд нийцүүлэх хандлага ( $U=8831.5$ ,  $p<.001$ ), гадаад урамшуулал дарамт ( $U=10924$ ,  $p=.042$ ) болон нийт дотоод ( $U=10718.5$ ,  $p=.024$ ) болон гадаад сэдэл ( $U=10186$ ,  $p=.005$ ), академик гүйцэтгэлийн ( $U=10081.5$ ,  $p=.003$ ) хувьд ялгаатай байсан. Харин сургууль сонголтын хувьд мэдлэг олж авах хандлага ( $U=9827$ ,  $p=.036$ ), хувийн үнэт зүйлд нийцүүлэх хандлага ( $U=7554.5$ ,  $p=.000$ ), гадаад урамшуулал дарамт ( $U=9912$ ,  $p=.045$ ), болон нийт гадаад сэдлийн ( $U=8735$ ,  $p<.001$ ) хувьд ялгаатай байв. Энэ нь өөрийн хүсэлтээр мэргэжил болон суралцах сургуулиа сонгосон оюутнуудын суралцах сэдэл болон академик гүйцэтгэл өндөр болохыг илтгэж байна.

*Хүснэгт 10. Мэргэжил сонголт болон сургууль сонголтоор харьцуулсан байдал- $n=400$*

Хувьсагч	Мэргэжил сонголт		Сургууль сонголт	
	$p$	(Mean Rank)	$p$	(Mean Rank)
<b>Дотоод сэдэл</b>	<b>.024</b>	Ө(207.00)>Б (174.48)	.390	Ө(202.81)>Б (189.82)
Мэдлэг олж авах сонирхол	<b>.001</b>	Ө(210.87)>Б (159.03)	<b>.036</b>	Ө(206.13)>Б (174.41)
Хувийн амжилт гаргах сонирхол	.339	Ө(203.25)>Б (189.48)	.147	Ө(204.38)>Б (182.51)
Сэтгэл ханамж, сэтгэл хөдлөлийн таашаал	.123	Ө(204.95)>Б (182.71)	.635	Ө(199.23)<Б (206.39)
<b>Гадаад сэдэл</b>	<b>.005</b>	Ө(208.67)>Б (167.83)	<b>.001</b>	Ө(209.45)>Б (159.03)
Хувийн үнэт зүйлд нийцүүлэх	<b>.001</b>	Ө(212.09)>Б (150.89)	<b>.001</b>	Ө(213.04)>Б (142.40)
Бусдын үнэлгээнд нийцүүлэх	.427	Ө(202.79)>Б (191.33)	.094	Ө(204.99)>Б (179.68)
Гадаад урамшуулал, дарамтаас хамаарах	<b>.042</b>	Ө(206.36)>Б (177.05)	<b>.045</b>	Ө(205.87)>Б (175.61)
<b>Суралцах сонирхолгүй байх</b>	<b>.001</b>	Ө(188.35)<Б (249.11)	<b>.001</b>	Ө(190.98)<Б (244.61)
<b>Академик гүйцэтгэл</b>	<b>.003</b>	Ө(209.00)>Б (166.52)	.308	Ө(203.19)>Б (188.04)

*Тайлбар: Mean Rank-дундаж ранк, p- ач холбогдлын утга, Ө-өөрийн сонголт, Б-бусад хүмүүсийн санал болгосон*

Дээрх үр дүнгээс онцлон тэмдэглэх зүйл нь өөрийн хүсэлтээр бус сургууль болон мэргэжлээ сонгосон оюутнуудын суралцах сонирхолгүй байдал нь өөрийн хүсэлтээр мэргэжил, сургуулиа сонгосон оюутнуудаас өндөр үзүүлэлттэй ( $U_{\text{мэргэжил сонголт}}=8911$ ,  $p<.001$ ;  $U_{\text{сургууль сонголт}}=8547.5$ ,  $p<.001$ ) байв. Үүнээс оюутны өөрийн хүсэл сонирхол нь суралцах сэдэл, академик гүйцэтгэлд чухал нөлөөтэй гэдгийг харж болно.

Тухайн үр дүнг хүйсээр ангилан авч үзвэл зөвхөн эрэгтэй оюутнуудын хувьд мэдлэг олж авах сонирхол ( $U_{\text{мэргэжил сонголт}}=2672$ ,  $p=.002$ ;  $U_{\text{сургууль сонголт}}=2396$ ,  $p=.009$ ), хувийн амжилт гаргах ( $U_{\text{сургууль сонголт}}=2514.5$ ,  $p=.022$ ), хувийн үнэт зүйлд нийцүүлэх ( $U_{\text{мэргэжил сонголт}}=2452$ ,  $p<.001$ ;  $U_{\text{сургууль сонголт}}=1715.5$ ,  $p<.001$ ), бусдын үнэлгээнд нийцүүлэх ( $U_{\text{сургууль сонголт}}=2540.5$ ,  $p=.027$ ), суралцах сонирхолгүй байх ( $U_{\text{мэргэжил сонголт}}=2168$ ,  $p<.001$ ;  $U_{\text{сургууль сонголт}}=1791$ ,  $p<.001$ ) болон нийт

дотоод ( $U_{\text{мэргэжил сонголт}}=2980.5$ ,  $p=.021$ ;  $U_{\text{сургууль сонголт}}=2614$ ,  $p=.045$ ), гадаад сэдэл ( $U_{\text{мэргэжил сонголт}}=2855$ ,  $p=.008$ ;  $U_{\text{сургууль сонголт}}=2025$ ,  $p<.001$ ), академик гүйцэтгэлийн ( $U_{\text{мэргэжил сонголт}}=2930$ ,  $p=.013$ ;  $U_{\text{сургууль сонголт}}=2273$ ,  $p=.003$ ) хувьд ялгаатай байсан. Харин эмэгтэй оюутнуудын хувьд мэдлэг олж авах сонирхол ( $U_{\text{мэргэжил сонголт}}=2490$ ,  $p=.031$ ), хувийн үнэт зүйлд нийцүүлэх ( $U_{\text{мэргэжил сонголт}}=1890$ ,  $p=.014$ ;  $U_{\text{сургууль сонголт}}=1855$ ,  $p=.022$ ), гадаад урамшуулал дарамт ( $U_{\text{мэргэжил сонголт}}=2023$ ,  $p=.048$ ), академик гүйцэтгэлийн ( $U_{\text{мэргэжил сонголт}}=1824$ ,  $p=.005$ ) хувьд ялгаатай байв.

### ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Манай судалгааны үр дүнд Шинжлэх Ухаан Технологийн их сургуулийн оюутнуудын академик гүйцэтгэл, суралцах сэдэл нь хүйс болон хувь хүний мэргэжил сонголтод мэдэгдэхүйц ялгаатай байгааг харуулсан. Хүйсийн хувьд эрэгтэй

оюутнууд эмэгтэй оюутнуудтай харьцуулахад суралцах сэдэл болон академик гүйцэтгэл тааруу байсан нь Зүүн Азийн бусад оронд хийгдсэн судалгаа болон АНУ-ын оюутнуудын дунд хийсэн судалгааны үр дүнтэй нийцэж байна (Reagan, 2009). Суралцах сэдлийн хувьд манай судалгаанд дотоод сэдэл болон гадаад сэдэл аль аль нь академик гүйцэтгэлтэй сул эерэг хамааралтай байсан. Энэ нь Ryan and Deci (2000), мөн Vallerand et al. (1992) нарын сэдлийн онолын үндэслэлтэй уялдаж байгаа бөгөөд суралцах сэдэл нэмэгдэх нь академик амжилтад эергээр нөлөөлдөг болохыг баталж өгсөн. Оюутнуудын сэтгэл зүйн сайн сайхан байдал, дотоод сэдэл өндөртэй байх нь академик гүйцэтгэлийг илүү хүчтэй дэмждэг гэдгийг энэхүү судалгаагаар харж болно (Stallman, 2010).

Мөн судалгаанд өөрийн хүсэлтээр мэргэжил, сургууль сонгосон оюутнуудын дотоод болон гадаад сэдэл, академик гүйцэтгэл харьцангуй өндөр байсан. Энэ нь Eccles & Wang (2012) нарын судалгаанд дурдсанчлан хувь хүний сонирхол, сонголт нь суралцах идэвх, оролцоонд хүчтэй нөлөө үзүүлдэг болон **оюутны мэргэжил болон сургууль сонголт** бөгөөд өөрийн хүсэл сонирхлоороо сонголт хийсэн оюутнууд илүү **сэдэл өндөртэй, сэтгэл хангалуун, гүйцэтгэл сайтай** байдаг гэсэн өмнөх судалгааны үр дүнгүүдийг баталж байна (Vansteenkiste et al., 2005). Түүнчлэн оюутнуудын академик гүйцэтгэлд зөвхөн хувь хүний сэдэл, сэтгэл зүйн асуудлаас гадна сургуулийн орчин,

багшийн хандлага, дэмжлэг хүчин зүйлс нөлөөлдөг (Stefanou et al., 2004). Иймд дараагийн судалгаагаар багшийн заах арга барил, үе тэнгийн нөлөөлөл, цахим орчин зэргийг академик гүйцэтгэл болон суралцах сэдэлтэй холбон судлах нь зүйтэй юм.

## ДҮГНЭЛТ

Академик гүйцэтгэл нь оюутны амжилт чанарыг илэрхийлэх хэмжигдэхүүн бөгөөд нийгэм эдийн засгийн байдал, хувь хүний сэтгэл зүйн үзүүлэлттэй хамааралтай байдаг. Иймд энэхүү судалгаа нь оюутны академик гүйцэтгэлд нөлөө үзүүлж буй суралцах сэдлийг хүйсийн хувьд харьцуулан судлахыг зорьсон. Зорилгын хүрээнд Шинжлэх Ухаан технологийн их сургуулийн бакалаврын түвшинд идэвхтэй суралцаж буй оюутнууд хамрагдсан. Судалгааны үр дүнгийн хувьд оюутны суралцах сэдэл болон академик гүйцэтгэл хоёрын хооронд эерэг хамаарал байсан. Оюутны суралцах сэдэл нь академик гүйцэтгэлийг 7.2 хувийг тайлбарлаж байсан бөгөөд суралцах сэдэл нэмэгдэх үед академик гүйцэтгэл сайжирч ( $B = 0.099$ ,  $SE = 0.027$ ,  $\beta = 0.177$ ,  $t = 3.66$ ,  $p < .001$ ) харин суралцах сонирхол багасах үед гүйцэтгэл суларч ( $B = -0.085$ ,  $SE = 0.022$ ,  $\beta = -0.191$ ,  $t = -3.94$ ,  $p < .001$ ) байв. Суралцах сэдэл болон академик гүйцэтгэлийн хувьд хүйсийн ялгаа илэрсэн бөгөөд эрэгтэй оюутантай харьцуулахад эмэгтэй оюутнууд суралцах сэдэл болон академик гүйцэтгэл өндөр байсан. Судалгааны үр дүнг дэлгэрүүлэх үүднээс мэргэжил

сонголт болон сургууль сонголтыг авч үзэхэд өөрийн хүсэлтээр мэргэжил болон сургуулиа сонгосон оюутнуудын суралцах сэдэл болон академик гүйцэтгэл өндөр байсан ба энэ нь хүйсийн хувьд ижил байв. Энэхүү судалгааг эцэслэн дүгнэвэл оюутны академик гүйцэтгэлд суралцах сэдэл чухал нөлөөтэй ба энэ нь хүйс болон мэргэжил сонголтын хувьд ялгаатай байна. Иймд оюутны суралцах сэдлийг дэмжиж өгснөөр боловсролын хүрээнд чадвартай боловсон хүчнийг бэлтгэх үндэслэл болно.

### НОМ ЗҮЙ

1. Eccles, J., & Wang, M. (2012). *Part I commentary: So what is student engagement anyway?* In Springer eBooks (pp. 133–145). [https://doi.org/10.1007/978-1-4614-2018-7\\_6](https://doi.org/10.1007/978-1-4614-2018-7_6)
2. Eisenberg, D., Downs, M. F., Golberstein, E., & Zivin, K. (2009). *Stigma and help seeking for mental health among college students. Medical Care Research and Review*, 66(5), 522–541. <https://doi.org/10.1177/1077558709335173>
3. Frujd, S. A., Nissinen, E. S., Pelkonen, M. U., Marttunen, M. J., Koivisto, A., & Kaltiala-Heino, R. (2007). *Depression and school performance in middle adolescent boys and girls. Journal of Adolescence*, 31(4), 485–498. <https://doi.org/10.1016/j.adolescence.2007.08.006>
4. Owens, M., Stevenson, J., Hadwin, J. A., & Norgate, R. (2012). *Anxiety and depression in academic performance: An exploration of the mediating factors of worry and working memory. School Psychology International*, 33(4), 433–449. <https://doi.org/10.1177/0143034311427433>
5. Ryan, R. M., & Deci, E. L. (2000). *Intrinsic and Extrinsic Motivations: classic definitions and new directions. Contemporary Educational Psychology*, 25(1), 54–67. <https://doi.org/10.1006/ceps.1999.1020>
6. Stallman, H. M. (2010). *Psychological distress in university students: A comparison with general population data. Australian Psychologist*, 45(4), 249–257. <https://doi.org/10.1080/00050067.2010.482109>
7. Turashvili, T., & Japaridze, M. (2012). *Psychological well-being and its relation to academic performance of students in georgian context. Problems of Education in the 21st Century*, 49(1), 73–80. <https://doi.org/10.33225/pec/12.49.73>
8. Vallerand, R. J., Pelletier, L. G., Blais, M. R., Briere, N. M., Senecal, C., & Vallieres, E. F. (1992). *The Academic Motivation Scale: a measure of intrinsic, extrinsic, and amotivation in education. Educational and Psychological Measurement*, 52(4), 1003–1017. <https://doi.org/10.1177/0013164492052004025>
9. Stefanou, C. R., Perencevich, K. C., DiCintio, M., & Turner, J. C. (2004). *Supporting Autonomy in the classroom: Ways teachers encourage student decision making and ownership. Educational Psychologist*, 39(2), 97–110. [https://doi.org/10.1207/s15326985e3902\\_2](https://doi.org/10.1207/s15326985e3902_2)
10. Schutte, A. R., & Spencer, J. P. (2002). *Generalizing the dynamic field theory of the A-not-B Error Beyond Infancy: Three-Year-Olds' Delay- and Experience-Dependent Location Memory Biases. Child Development*, 73(2), 377–404. <https://doi.org/10.1111/1467-8624.00413>
11. Pearman, A. (2009). *Basic cognition in adulthood: Combined effects of sex and personality. Personality and Individual Differences*, 47(4), 357–362. <https://doi.org/10.1016/j.paid.2009.04.003>
12. APA PsycNet. (n.d.). <https://psycnet.apa.org/buy/1987-26534-001>
13. Beiter, R., Nash, R., McCrady, M., Rhoades, D., Linscomb, M., Clarahan, M., & Sammut, S. (2014). *The prevalence and correlates of depression, anxiety, and stress in a sample of college students. Journal of Affective Disorders*, 173, 90–96.

- <https://doi.org/10.1016/j.jad.2014.10.054>
14. Chen, B., Bastedo, K., & Howard, W. (2018). Exploring Best Practices for Online STEM Courses: Active Learning, Interaction & Assessment Design. *Online Learning, 22*(2). <https://doi.org/10.24059/olj.v22i2.1369>
  15. Deci, E. L., & Ryan, R. M. (2000). The “What” and “Why” of goal pursuits: human needs and the Self-Determination of behavior. *Psychological Inquiry, 11*(4), 227–268. [https://doi.org/10.1207/s15327965pli1104\\_01](https://doi.org/10.1207/s15327965pli1104_01)
  16. Park, M., & Jung, S. J. (2021). Association between menstrual cycle irregularity and suicidal ideation among Korean women: Results from the Korea national health and nutrition examination survey (2010–2012). *Journal of Affective Disorders, 293*, 279–284. <https://doi.org/10.1016/j.jad.2021.06.052>
  17. Randall, E. T., Bohnert, A. M., & Travers, L. V. (2015). *Understanding affluent adolescent adjustment: The interplay of parental perfectionism, perceived parental pressure, and organized activity involvement*. *Journal of Adolescence, 41*(1), 56–66. <https://doi.org/10.1016/j.adolescence.2015.03.005>
  18. Vansteenkiste, M., Zhou, M., Lens, W., & Soenens, B. (2005). Experiences of autonomy and control among Chinese learners: vitalizing or immobilizing? *Journal of Educational Psychology, 97*(3), 468–483. <https://doi.org/10.1037/0022-0663.97.3.468>
  19. Voyer, D., & Voyer, S. D. (2014). Gender differences in scholastic achievement: A meta-analysis. *Psychological Bulletin, 140*(4), 1174–1204. <https://doi.org/10.1037/a0036620>
  20. York, T. T., Gibson, C., & Rankin, S. (2015). Defining and measuring academic success. *Practical Assessment, Research & Evaluation, 20*(5), 1–20. <https://doi.org/10.7275/hz5x-tx03>